**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.02.23. № 1/227

танай ______________ -ны № ______________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ Б.ПҮРЭВДАГВА ТАНАА

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлт, төлбөрийн актыг хүргүүлж байна.

Төлбөрийн актын биелэлтийг нотлох баримтын хамт 4 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Хавсралт    хуудастай

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР    Б. МӨНХБАТ

5030518

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БНА-2024/29/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2024 оны 02 дугаар сар 24 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын<br>Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Ахлах аудитор М.Алтантуяа<br>Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК<br>Захирал Г.Саранчимэг<br>Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon @gmail.com<br>Аудитор: О.Мандах<br>Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 9
4.АУДИТЫН ТАЙЛАН ........ 14
4.1 Ерөнхий зүйл ........ 14
4.2 Материаллаг байдал ........ 14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15
4.5.1 Завсрын аудитын талаар ........ 15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 16
5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 16
5.1 Төлбөрийн акт ........ 16
6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БШУС | Боловсрол, шинжлэх ухааны сайд |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| НББBББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.02.23. № 2/35

танай____________-ны № ______________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨГЖИМТ
ДРАМЫН ТЕАТРЫН ДАРГА
Б.ПҮРЭВДАГВА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 1,779,4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,771,9 мянган төгрөгийг зарцуулж, төсөвт 3,676.2 мянган төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст харилцах дансанд 4,851.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Аудитын гол асуудал**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах,нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

5020154

Аудитаар эрх бүхий этгээдийн тушаал шийдвэргүйгээр 1,116,000 төгрөгийн цалинг тооцож бодож олгосон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтрээгүй байгаа нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 85.0 хувьтай тайлагнаж Баянхонгор аймгийн Соёл урлагын газраас 80 хувьтай дүгнэсэн байна.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **368,708,489.32** | **416,331,317.54** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **1,811,172.32** | **4,851,700.54** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **1,811,172.32** | **4,851,700.54** |
| **31210** | **Төгрөг** | **1,811,172.32** | **4,851,700.54** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 1,811,172.32 | 4,851,700.54 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **366,897,317.00** | **411,479,617.00** |
| **35100** | **Түүхий эд материал** | **201,500.00** | **99,000.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 201,500.00 | 99,000.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **364,145,817.00** | **408,830,617.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,959,592.00 | 5,953,992.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 26,489,100.00 | 27,295,300.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,300,000.00 | 0 |
| 35450 | Барилгын засварын материал | 80,000.00 | 80,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 328,317,125.00 | 375,501,325.00 |
| 35600 | Мал амьтад | 2,550,000.00 | 2,550,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,014,220,370.38** | **1,028,636,705.47** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,014,220,370.38** | **1,028,636,705.47** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **802,615,370.53** | **814,031,705.66** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,635,330,707.66 | 1,635,330,707.66 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -943,094,808.24 | -972,563,901.96 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 75,000,000.00 | 65,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -46,874,999.76 | -54,541,666.56 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 349,094,182.60 | 427,666,182.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -314,595,420.17 | -332,745,507.76 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 167,891,503.00 | 169,331,503.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -158,021,394.56 | -163,481,211.32 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 37,000,000.00 | 37,000,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 6,250,000.00 | 7,900,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -6,250,000.00 | -6,250,000.00 |
| 39217 | Ном | 885,600.00 | 885,600.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **211,604,999.85** | **214,604,999.81** |
| 39301 | Програм хангамж | 2,130,000.00 | 2,130,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -450,000.00 | -450,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 246,687,355.00 | 249,887,355.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -36,762,355.15 | -36,962,355.19 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,382,928,859.70** | **1,444,968,023.01** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **296,170.67** | **67,681.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **296,170.67** | **67,681.00** |
| **41300** | **Өглөг** | **296,170.67** | **67,681.00** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 228,489.67 | 0 |
| **41360** | **Бусад өглөг** | **67,681.00** | **67,681.00** |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 67,681.00 | 67,681.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,382,632,689.03** | **1,444,900,342.01** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,382,632,689.03** | **1,444,900,342.01** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 945,688,163.91 | 945,688,163.91 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 945,688,163.91 | 945,688,163.91 |

005 ӨРГӨДӨЛ, САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **-63,130,945.57** | **-863,292.59** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -1,446,038,015.60 | -63,130,945.57 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,382,907,070.03 | 62,267,652.98 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 500,075,470.69 | 500,075,470.69 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,382,928,859.70** | **1,444,968,023.01** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,175,940,270.00** | **1,827,694,629.66** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **58,999,470.00** | **73,029,950.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **58,999,470.00** | **73,029,950.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **25,855,470.00** | **24,029,950.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 25,855,470.00 | 24,029,950.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 0.00 | 49,000,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 33,144,000.00 | 0 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,116,940,800.00** | **1,754,664,679.66** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **872,921,600.00** | **1,484,516,479.66** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 872,921,600.00 | 1,484,516,479.66 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **244,019,200.00** | **270,148,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 244,019,200.00 | 270,148,200.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,183,706,503.66** | **1,761,864,476.48** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,183,706,503.66** | **1,761,864,476.48** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,107,955,442.47** | **1,544,023,819.29** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **660,793,777.18** | **1,033,155,336.44** |
| 210101 | Үндсэн цалин | 555,070,703.06 | 709,600,837.61 |
| 210102 | Нэмэгдэл | 48,165,616.00 | 180,290,439.49 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 36,996,000.00 | 51,089,128.89 |
| 210104 | Урамшуулал | 6,494,817.00 | 92,174,930.45 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 14,066,641.12 | 0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **82,621,276.49** | **128,940,792.71** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 56,184,216.49 | 87,700,049.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,612,320.29 | 10,317,652.83 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,283,217.23 | 8,254,122.13 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,321,274.26 | 2,053,913.08 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,220,248.22 | 20,615,054.94 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **216,932,616.70** | **258,471,986.81** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,972,271.70 | 6,410,614.81 |
| 210302 | Түлш, халаалт | 204,886,733.00 | 246,301,440.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,073,612.00 | 5,759,932.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **21,265,203.79** | **32,919,850.62** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,428,500.00 | 6,106,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,263,221.00 | 4,617,065.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,125,906.79 | 2,421,135.62 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,198,000.00 | 1,125,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,249,576.00 | 18,650,050.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **625,100.00** | **0** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **12,460,400.00** | **9,782,000.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,790,000.00 | 0 |
| 210604 | Урсгал засвар | 10,670,400.00 | 9,782,000.00 |

005 ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **554,000.00** | **0** |
| 210702 | Дотоод албан томилолт | 554,000.00 | 0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **26,778,586.00** | **11,440,792.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 25,358,716.00 | 9,264,408.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0 | 700,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 297,450.00 | 0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 239,220.00 | 435,184.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 77,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0 | 180,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 806,200.00 | 806,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **85,924,482.31** | **69,313,060.71** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0 | 2,429,896.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 85,924,482.31 | 66,883,164.71 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **75,751,061.19** | **217,840,657.19** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **71,255,300.00** | **214,164,444.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 0 | 4,939,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 69,489,500.00 | 48,547,800.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0 | 159,909,144.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,765,800.00 | 768,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **4,495,761.19** | **3,676,213.19** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,495,761.19 | 3,676,213.19 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **-7,766,233.66** | **65,830,153.18** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **0** | **3,562,500.20** |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | 0 | 3,562,500.20 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-7,766,233.66** | **62,267,652.98** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,142,796,270.00** | **1,778,694,629.66** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **25,855,470.00** | **24,029,950.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **25,855,470.00** | **24,029,950.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **25,855,470.00** | **24,029,950.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 25,855,470.00 | 24,029,950.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,116,940,800.00** | **1,754,664,679.66** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **872,921,600.00** | **1,484,516,479.66** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 872,921,600.00 | 1,484,516,479.66 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **244,019,200.00** | **270,148,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 244,019,200.00 | 270,148,200.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,133,325,097.68** | **1,739,792,101.44** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,133,325,097.68** | **1,739,792,101.44** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,057,574,036.49** | **1,521,951,444.25** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **660,771,987.51** | **1,033,383,826.11** |
| 210101 | Үндсэн цалин | 550,249,532.39 | 709,600,837.61 |
| 210102 | Нэмэгдэл | 47,454,923.00 | 180,518,929.16 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 36,492,000.00 | 51,089,128.89 |
| 210104 | Урамшуулал | 6,494,817.00 | 92,174,930.45 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 20,080,715.12 | 0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **82,621,276.49** | **128,940,792.71** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 56,184,216.49 | 87,700,049.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,612,320.29 | 10,317,652.83 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,283,217.23 | 8,254,122.13 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,321,274.26 | 2,053,913.08 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,220,248.22 | 20,615,054.94 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **216,932,616.70** | **258,471,986.81** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,972,271.70 | 6,410,614.81 |
| 210302 | Түлш, халаалт | 204,886,733.00 | 246,301,440.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,073,612.00 | 5,759,932.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **15,080,777.79** | **13,487,450.62** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,925,100.00 | 2,696,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,263,221.00 | 4,617,065.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,125,906.79 | 2,421,135.62 |
| 210404 | Ном, хэвлэл | 0 | 0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,198,000.00 | 1,125,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,568,550.00 | 2,626,850.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **3,974,450.00** | **0** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,974,450.00 | 0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **11,208,526.00** | **8,000,000.00** |
| 210602 | Тавилга | 200,000.00 | 0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,468,626.00 | 0 |
| 210604 | Урсгал засвар | 8,539,900.00 | 8,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **554,000.00** | **0** |
| 210702 | Дотоод албан томилолт | 554,000.00 | 0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **46,430,402.00** | **49,050,092.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 46,430,402.00 | 48,870,092.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0 | 180,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **20,000,000.00** | **30,617,296.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,000,000.00 | 30,617,296.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **75,751,061.19** | **217,840,657.19** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **71,255,300.00** | **214,164,444.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 69,489,500.00 | 48,547,800.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0 | 159,909,144.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,765,800.00 | 768,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **4,495,761.19** | **3,676,213.19** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,495,761.19 | 3,676,213.19 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **9,471,172.32** | **38,902,528.22** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **7,660,000.00** | **35,862,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **7,660,000.00** | **35,862,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **7,660,000.00** | **35,862,000.00** |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 7,660,000.00 | 35,862,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-7,660,000.00** | **-35,862,000.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **1,811,172.32** | **3,040,528.22** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 1,811,172.32 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,811,172.32 | 4,851,700.54 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **945,688,163.91** | **492,075,470.69** | **(41,232,675.39)** | **1,396,530,959.21** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **945,688,163.91** | **492,075,470.69** | **-41,232,675.39** | **1,396,530,959.21** |
| **4** | **Тайлант үеийн үр дүн** | **0** | **0** | **-13,857,655.52** | **-13,857,655.52** |
| **5** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **945,688,163.91** | **500,075,470.69** | **-63,130,945.57** | **1,382,632,689.03** |
| **6** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **945,688,163.91** | **500,075,470.69** | **-63,130,945.57** | **1,382,632,689.03** |
| **7** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **945,688,163.91** | **500,075,470.69** | **-63,130,945.57** | **1,382,632,689.03** |
| 8 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | 62,267,652.98 | 62,267,652.98 |
| **9** | **2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **945,688,163.91** | **500,075,470.69** | **-863,292.59** | **1,444,900,342.01** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,779,408,200.00** | **1,771,977,888.25** | **7,430,343.75** | **99.6** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,779,408,232.00** | **1,771,977,888.25** | **7,430,343.75** | **99.6** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,565,243,800.00** | **1,557,813,444.25** | **7,430,355.75** | **99.5** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,036,340,800.00** | **1,033,383,826.11** | **2,956,973.89** | **99.7** |
| 210101 | Үндсэн цалин | 709,865,000.00 | 709,600,837.61 | 264,162.39 | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 178,513,300.00 | 180,518,929.16 | - 2,005,629.16 | 101.1 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 52,096,000.00 | 51,089,128.89 | 1,006,871.11 | 98.1 |
| 210104 | Урамшуулал | 95,866,500.00 | 92,174,930.45 | 3,691,569.55 | 96.1 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **129,542,200.00** | **128,940,792.71** | **601,407.29** | **99.5** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 88,088,700.00 | 87,700,049.73 | 388,650.27 | 99.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,363,200.00 | 10,317,652.83 | 45,547.17 | 99.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,290,700.00 | 8,254,122.13 | 36,577.87 | 99.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,072,700.00 | 2,053,913.08 | 18,786.92 | 99.1 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,726,900.00 | 20,615,054.94 | 111,845.06 | 99.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **262,148,200.00** | **258,471,986.81** | **3,676,213.19** | **98.6** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,523,000.00 | 6,410,614.81 | 2,112,385.19 | 75.2 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 248,375,200.00 | 246,301,440.00 | 2,073,760.00 | 99.2 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,250,000.00 | 5,759,932.00 | -509,932.00 | 109.7 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **13,587,800.00** | **13,487,450.62** | **100,349.38** | **99.3** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,703,500.00 | 2,696,800.00 | 6,700.00 | 99.8 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,617,400.00 | 4,617,065.00 | 335.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,440,000.00 | 2,421,135.62 | 18,864.38 | 99.2 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,200,000.00 | 1,125,600.00 | 74,400.00 | 93.8 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,626,900.00 | 2,626,850.00 | 50.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **31,172,000.00** | **31,172,000.00** | **0.00** | **100.0** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 23,172,000.00 | 23,172,000.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 8,000,000.00 | 8,000,000.00 | 0.00 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **60,392,800.00** | **60,300,092.00** | **92,708.00** | **99.8** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 60,212,800.00 | 60,120,092.00 | 92,708.00 | 99.8 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 180,000.00 | 180,000.00 | 0.00 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **32,060,000.00** | **32,057,296.00** | **2,704.00** | **100.0** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,060,000.00 | 32,057,296.00 | 2,704.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **214,164,432.00** | **214,164,444.00** | **-12.00** | **100.0** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **214,164,432.00** | **214,164,444.00** | **-12.00** | **100.0** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,939,500.00 | 4,939,500.00 | 0.00 | 100.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 53,146,600.00 | 48,547,800.00 | **4,598,800.00** | **91.3** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 155,310,332.00 | 159,909,144.00 | -4,598,812.00 | 103.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 768,000.00 | 768,000.00 | 0.00 | 100.0 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,779,408,200.00** | **1,778,694,665.66** | **713,566.34** | **100.0** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,485,233,70.000** | **1,484,516,515.66** | **717,216.34** | **100.0** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,485,233,700.00 | 1,484,516,515.66 | 717,216.34 | 100.0 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **270,148,200.00** | **270,148,200.00** | **0.00** | **100.0** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 270,148,200.00 | 270,148,200.00 | 0.00 | 100.0 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **24,026,300.00** | **24,029,950.00** | **-3,650.00** | **100.0** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 24,026,300.00 | 24,029,950.00 | -3,650.00 | 100.0 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 0.00 | 0 | 0.00 | #DIV/0! |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 1,811,172.32 | -1,811,172.32 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 4,851,700.54 | -4,851,700.54 | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **0.00** | **0** | **0.00** | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1.00** | **0.00** | **100.0** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1.00 | **0.00** | **100.0** |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **60** | **60.00** | **0.00** | **100.0** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1.00 | **000** | **100.0** |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 45 | 45.00 | **0.00** | **100.0** |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 9 | 9.00 | **0.00** | **100.0** |
| 620004 | Гэрээт ажилтан | 5 | 5 | **0.00** | **100.0** |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театр нь" Монголын соёл урлагын үнэт өвийг түгээн дэлгэрүүлж, сурталчлах,орчин үеийн уран бүтээлийн чанар, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, төрөөс баримтлах соёлын бодлого, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгасан асуудлыг бие даан хэрэгжүүлэх" зорилго тавин соёлын удирдлагын менежментийг зах зээлийн эдийн засагт нийцүүлэн өөрчлөн шинэчлэх бодлого хэрэгжүүлэж ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Соелын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### . 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театр нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн хөгжимт драмын театрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 62,039.2 мянган төгрөгөөр буюу 4.5 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 1,811,1 | 4,851,7 | 3,040,5 |
| Авлага | 0 | - | 0 |
| Бараа материал | 366,897,3 | 411,479,6 | 44,582,3 |
| Үндсэн хөрөнгө | 2,520,269,3 | 2,595,631,3 | 75,362,0 |
| Хуримтлагдсан элэгдэл | -1,506,048,9 | -1,566,994,6 | -60,945,7 |
| **Нийт хөрөнгө** | **1,382,928,8** | **1,444,968,0** | 62,039,2 |
| Өр төлбөр | 296,17 | 67,68 | -228,49 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,382,632,6 | 1,444,900,3 | 62,267,7 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,382,928,8** | **1,444,968,0** | 62,039,2 |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн хөгжимт драмын театрын санхүүгийн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан данс нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд оны эхэнд 1,811.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 4,851.7 мянган төгрөгийн өмнөх оноос 3,040.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 85,379.9 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч үйл ажиллагаанд 40,797.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулж бараа материалын үлдэгдэл 44,582.0 мянган төгрөгөөр өмнөх оноос өссөн байна.

Тайлант онд авлагагүй байна. Өглөг тайлант оноос 228.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 35,862.0 мянга, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 11 сарын 13-ний өдрийн 107 тоот тушаалаар 49,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч нийт 84,862.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны 3 сарын 20-ны өдрийн А/147 дугаар захирамжаар 9,500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэлийг бусад байгуулагад шилжүүлэн үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 75,362.0 мянган төгрөгөөр өмнөх оноос нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 62,267.7 мянган төгрөгөөр нэмэгдэж 1,444,900.3 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 62,267.7 мянган төгрөгөөр буурч 1,444,968.0 мянган төгрөг болсон байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,818,900.2 мянган төгрөгөөр төлөвлөж, зарлагыг 1,818,900.2 мянган төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас 678,098.2 мянган төгрөгөөр буурч 1,140,801.4 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 344,432.3 мянган төгрөг болгож 1,485,233.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь цалин хөлс нэмэгдсэн, соёлын ажилтанд 5 жилийн нэг удаагийн тэтгэмж олгосонтой холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71702 (Соел урлаг) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 1,485,233,7 мянган төгрөг санхүүжилтийг авч, үйл ажиллагааны орлогоос 24,026.3 мянга, орон нутгийн төсвйин санхүүжилтээр 270,148.2 мянган төгрөг нийт 1,779,408.2 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй, гүйцэтгэлээр 1,771,977,9 мянган төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 4,851.7 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 270,148.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 98.6 хувь буюу 266,472.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй, орон нутгийн төсвийн санхүүжилтийн харилцах дансны зарцуулаагүй үлдэгдэл 3,676.2 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөг/*

| № | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | Хөтөлбөр 71702 / Соёл урлаг/ | | | | |
| 1 | 80101Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,223,078,800.00 | 1,219,897,457.44 | 3,181,342.6 | 99.74% |
| 2 | 80214 Уран бүтээл хийх зардал | 20,000,000.00 | 19,976,000.00 | 24,000.0 | 99.88% |
| 3 | 81855 Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт | 32,930,000.00 | 32,381,200.00 | 548,800.0 | |
| 4 | 83603 Дээд шатны төсвөөс хувиарьласан нэмэлт санхүүжилт | 24,026,300.00 | 24,026,300.00 | 0.0 | 100.00% |
| 5 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж | 209,224,900 | 209,224,944.0 | -44.0 | 100.00% |
| 6 | 80112 Нийтлэг үйлчилгээ | 270,148,200.00 | 266,471,986.81 | 3,676,213.2 | 98.64% |
| ДҮН | | 1,779,408,200.00 | 1,771,977,888.25 | 7,430,311.76 | 99.58% |

/

Эх сурвалж:2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
005 ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театр нь тайлант онд төсвийн хөрөнгөөр бараа материалын дансанд 85,379.9 мянган төгрөгийн бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд 35,862.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна. Худалдан авсан бараа материалыг шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн ахлах аудитор О. Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг театрын дарга Б.Пүрэвдагва, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Э.Эрдэнэхүү нар зурж, нярваар 2023 оны 1 дүгээр сараас 10 сарын 2-ны өдөр хүртэл Г. Нандинцэцэг, 11 дүгээр сараас С. Долгормаа нар ажиллажээ.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны нийт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 3 дугаар улирлын нийт зардлын 1,372,777.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,727.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 10,295.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно. Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны

005 ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ӨӨРЧЛӨЛТ ГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

3 сарын 20-ны өдрийн А/147 дугаар захирамжаар 9,500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэлийг бусад байгуулагад шилжүүлсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,752,909.6 мянган төгрөгийн 24 гүйлгээ, зарлагын 445,03.5 мянган төгрөгийн 24 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай шийдвэрийг хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

*Завсрын аудит хийгдээгүй болно.*

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б. Нарангэрэл гүйцэтгэж, нийцлийн аудиттай холбоотой 2 албан шаардлага,1,517.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, менежментийн захидлаар 3,842.5 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 2 | - | 2 | - | - |
| Албан шаардлага | 1 | 1517.0 | 1 | 1517.0 | 100 |
| Зөвлөмж | 2 | 3842.9 | 2 | 3842.9 | 100.0 |
| Нийт дүн | 5 | 6,359.5 | 5 | 6,359.5 | 100.0 |

*Эх сурвалж: Баянхонгор сумын Хөгжимт драмын театрын 2023.05.22-ны өдрийн 34 дугаар албан бичиг*

Аудитаар өгсөн төлбөрийн актын төлбөр 1,517.0 мянган төгрөгийг 2023.5.20-ны өдөр 10003000947тоот дансанд шилжүүлж биелэлтийг 2023.5.22-ны өдрийн 34 дугаар албан бичгээр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,116.0 мянган төгрөгийн 1 зөрчил[1] илэрсэнд төлбөрийн акт тогтоов..

### 5.1 Төлбөрийн акт

1.Илрүүлэлт: Тасалбар түгээврийн касс, нярав С.Долгормааг Хөгжимт драмын театрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 1-ны өдрийн Б/60 тушаалаар “Туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ байгуулах тухай” томилсон байхад 10 дугаар сард эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр 1,116.0 мянган төгрөгийн цалинг тооцож бодож олгосон.

Шийдвэрлэсэн нь: Ажилд томилсон тушаал гараагүй байхад тооцож бодож олгосон 1,116.0 мянган төгрөгийн цалингийн төлбөрийг нягтлан бодогчоор төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Дээрх төлбөрийн актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 4 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү..

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлантай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тасалбар түгээврийн касс, нярав С. Долгормааг Хөгжимт драмын театрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 1-ны өдрийн Б/60 тушаалаар “Туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ байгуулах тухай” томилсон байхад 10 дугаар сард эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр 1,116,000 төгрөгийн цалинг тооцож бодож олгосон. | 1 | 1,116.0 | 1 | 1116.0 | | | | |
| Нийт дүн | 1 | 1,116.0 | 1 | 1,116.0 | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo---

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 63/14210573/ БНА/2024/(29)/НА-СА-ТИЗ Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тасалбар түгээврийн касс, нярав С. Долгормааг Хөгжимт драмын театрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 1-ны өдрийн Б/60 тушаалаар "Туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ байгуулах тухай" томилсон байхад 10 дугаар сард эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр 1,116,000 төгрөгийн цалинг тооцож бодож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.2 Ажил олгогч дараах үндсэн үүрэгтэй 43.2.1 гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирсон цалин хөлсийг тогтоосон хугацаанд ажилтанд олгох, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр тогтоогоогүй бол хөдөлмөрийн нормыг үндэслэлтэй тогтоох, аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөж байгаа цалин хөлсний тогтолцоо, журмыг ажилтанд мэдээлэх", Нийтийн албанд нийтийн болон болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.Албан тушаалтан нь хууль дээдлэх зарчимд захирагдан, албан үүргээ иргэдийн итгэл хүлээхүйц, тэгш, шударга, хариуцлагатайгаар гүйцэтгэж, албаны ёс зүйг сахина. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтуудыг зөрчсөн. Эрх ба үүрэг,"Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах,

5050132

зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.4 дахь "Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажилд томилсон тушаал гараагүй байхад тооцож бодож олгосон 1116000 төгрөгийн цалингийн төлбөрийг нягтлан бодогч Э.Эрдэнэхүүгээр төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь татвар хураамжийн орлого 100030000947 тоот дансанд төлүүлэхээр төлбөрийг акт тогтоов.

2.Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 03 дугээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын дарга Б.Пүрэвдагва, нягтлан бодогч Э.Эрдэнэхүү нарт хариуцуулав[1].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[2]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА: Б. МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР: О. МАНДАХ

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[2] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно